МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 18 өдөр Дугаар А/161 Ховд

# Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан журмын 2 дугаар зүйлийн 2.1.1, аймгийн Онцгой комиссын 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 18 дугаар шийдвэрийн 8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Эрүүл мэндийн газраас хамгаалах хувцас худалдан авахад 3960.0 мянган төгрөг, халуун хэмжигч, нүдний шилийг худалдан авахад 1540.0 мянган төгрөг нийт 5500.0 мянган төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Тус арга хэмжээнд зарцуулах 5500.0 мянган төгрөг /таван сая таван зуун мянган/- ийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.ДҮГЭРЖАВ

02 00726

Аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/161 дүгээр захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ ХАМГААЛАХ ХУВЦАС, ХАЛУУН ХЭМЖИГЧ ХУДАЛДАН АВАХ ЗАРДЛЫН ЖАГСААЛТ

| дд | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Тоо | Нэгж үнэ /төгрөг/ | Нийт үнэ /мянган төгрөг/ |
|---|---|---|---|---|---|
| 1. | Хамгаалах хувцас худалдан авах | ш | 220 | 18000.00 | 3960.0 |
| 2 | Зайнаас халуун хэмжигч | ш | 11 | 140000.00 | 1540.0 |
| | Нийт дүн | | | | 5500.0 |

-оОо-